



**“БАГАХАНГАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ,  
ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 8/01

Улаанбаатар хот

**Хөдөлмөрийн дотоод журмыг  
шинэчлэн батлах тухай**

Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 146 дугаар тогтоолоор батлагдсан “Багахангайн Үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын “Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын “Хөдөлмөрийн дотоод журмын “7.1.5 “Ажилтанд Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасны дагуу ажилласан жилийн нэмэгдлийг тооцож олгоно” гэж заасныг “Ажилтанд Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад заасны дагуу ажилласан жилийн нэмэгдлийг тооцож олгоно, 7.1.6 “Хоол унааны мөнгийг сар бүр ажлын хоногоор тооцон олгоно. Хоолны мөнгийг 1 өдрийн 6000 төгрөг, унааны мөнгийг 1 өдрийн 1000 төгрөгөөр тус тус олгоно” гэж заасныг Хоолны мөнгийг 1 өдрийн 10000 төгрөг, унааны мөнгийг 1 өдрийн 1000 төгрөгөөр өөрчлөн тус тус баталсугай.

2.Хөдөлмөрийн дотоод журмыг албан хаагчдад танилцуулж, журмын хэрэгжилтийг хангаж хяналт тавьж ажиллахыг “Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Үйл ажиллагаа, хүний нөөцийн менежер (Г.Буян-Ундрах)-т даалгасугай.

3.Шинэчлэн баталсан Хөдөлмөрийн дотоод журмыг 2023 оны 01 дүгээр сараас мөрдэж ажилласан жилийн нэмэгдэл болон хоол, унааны мөнгийг зохих хууль, тогтоомжийн дагуу тооцож олгохыг Нягтлан бодогч (Г.Батням)-д зөвшөөрсүгэй.



Ц.ЖАМБАЛЦЭРЭН